



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан долоон иргэн, аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан дөрвөн иргэн, аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.


4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 02  
өдрийн 116 тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.02

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Сан хорго ХХК	Сан	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу 47
2	Мөнх Оюу ХХК	Анар	Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 45
3	Ээвж номт ХХК	Бамбино	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Доржийн гудамж 38
4	Асгат жавхланта ХХК	Эрмүүн	Баянгол дүүрэг, 13-р хороо, 2в/8
5	Чингис Хаан Цогцолбор ХХК	Чингис хаан	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Токиогийн гудамж 49
6	Хасабэ интернэйшнл ХХК	Цэцэг	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 18
7	Иргэн П.Амардэлгэр	Ундрам	Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Намьянжугийн гудамж 20

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 02  
өдрийн 176 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭНИЙ НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.02

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Анун хонгор од ХХК	Голден трий	Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Их тойруу 11/1
2	Цог ХХК	Цог	Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Тэнгис кино театрын ард

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 02  
өдрийн 116 тоот тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.09.02

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	"СББББ" ЗБ Нөхөрлөл	Оюу	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Дандарын гудамж 10
2	Иргэн С.Нарантуяа	Ли́ла	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Доржийн гудамж 48/3
3	Улаан Царам ХХК	Эм Жи	Хан-Уул дүүрэг, 10-р хороо, 64-р байрны дэргэд
4	Иргэн Ж.Энхбаатар	Лассо	Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 43/1

-ooOoo-